

**11-р сарын 13-ны өдрөөс эхлэн олон нийтийн газар
амны хаалт зүүгээгүй тохиолдолд
100,000 вон хүртэл торгууль ногдуулна.**

□ Торгууль ногдуулах

- ▲ Амны хаалт зүүгээгүй тохиолдолд
- ▲ Амны хаалт зүүхдээ хамар амны хэсгийг бүрэн далдлаагүй тохиолдолд
- ▲ Торон болон хавхалгатай амны хаалт, хүзүүний алчуур гэх мэт хувцасаар хамар амаа далдалсан үед

👉 Хүлээн зөвшөөрөгдсөн амны хаалтны төрлүүд

: KF94, KF80, нарийн ширхэглэгт тоосонцорийг шүүж чадах маск, мэс заслын маск, даавуун маск, нэг удаагийн маск гэх мэт.

Амны хаалт заавал зүүх үүргийг зай барих үе шагнаас хамарч халдварт өвчин тархах эрсдэлтэй байгууламж · газарт харилцан адилгүй хэрэгжүүлнэ.

Нийгмийн харилцаанаас зай барих 1-р үе шат : Голчлон · ерөнхий хяналт тавих (23 төрөл), нийтийн тээвэр, цуглаан · эсэргүүцлийн жагсаал болж буй газар, эрүүл мэндийн байгууллага · эмийн сан, асрамжийн газар, өдөр · шөнийн хамгаалах газар, шатны байгууламж, биеийн тамир спортын газар, өндөр эрсдэлтэй ажлын байр (лавлах төв, ачилт, түгээлтийн төв), орон нутгийн засаг захиргаанд мэдэгдэж, зөвшилцсөн 500 ба түүнээс дээш хүнтэй уулзалт, арга хэмжээ.

Ангилал	Хамаарах байгууламж
Голчлон хяналт тавих газар (9 төрөл)	<ul style="list-style-type: none"> ▲ 5 төрлийн зугаа цэнгээний газар(клуб, өрөөтэй цэнгээний газар гэх мэт цэнгээний газар, дуулж болохуйц уушийн газар, бүжиглэх боломжтой уушийн газар, өсвөр насныханд зориулсон бүжгийн клуб, хоорондоо танилцах боломжтой уушийн газар) ▲ Дууны дасталын танхим ▲ Дотор зогсож үзэх тоглолын танхим ▲ Гэрээр худалдаа хийх зэрэг шууд борлуулах сурталчилгааны танхим. ▲ Хоолны газар, кафе (энгийн хоолны газар, зам дагуу амрах газрын цайны газар, талх нарийн боовны дэлгүүр)
Ерөнхий хяналт тавих газар (14 төрөл)	<ul style="list-style-type: none"> ▲ Хуримын ордон ▲ оршуулах ёслолын газар ▲ дугуйлан (сургалтын танхим) ▲ мэргэжлийн сургалтын газар ▲ Усанд орох газар ▲ Тоглолын танхим ▲ Кино театр ▲ Тоглоомын талбай · Парк · Усан парк ▲ Тоглоомын газар · Олон төрлийн зориулалтай(тоглох, дуулах, манга унших) өрөө гэх мэт. ▲ Биеийн тамир спортын газар ▲ Үсчин, Гоо сайхны салон ▲ Дэлгүүр, март, их дэлгүүр ▲ Ном унших газар, хичээл хийх зориулалттай кафе

- Нийгмийн харилцаанаас зай барих 1,5 -р үе шат : 1-р үе шатны байгууламж болон бие тамир спортын талбай орно.
- Нийгмийн харилцаанаас зай барих 2 -р үе шат: Бүх байр танхим болон эрсдэл өндөртэй үйл ажиллагаа явуулж буй гадна талбай
- Нийгмийн харилцаанаас зай барих 2,5 болон 3-р үе шат: Бүх байр танхим болон 2метрээс илүү зайг барих боломжгүй гадна талбай
- Хариуцагч(удирдагч) болон ажилтан үйлчлүүлэгч амны хаалт заавал зүүх үүрэгтэй.

※ Торгууль ногдуулах байгууламж, газрын талаар корона19 халдвар өвчний тархалтын байдлыг харгалзан орон нутгий н засаг захиргаа тус бүрдээ зохицуулалт хийж болно.

□ Хамаарахгүй тохиолдол

▲ Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэх мэт бусдын тусламжгүйгээр амны хаалтаа зүүж эсвэл тайлж чадахгүй хүн

▲ Эмчийн дүгнэлтээр амны хаалт зүүсэн тохиолдолд амьсгалахад хэцүү хүн

▲ 14 нас хүрээгүй хүүхэд

▲ Нүүрээ угаах, хоол идэх, эмчилгээ хийлгэх, усан бассейн • усанд орох гэх мэт тохиолдолд

▲ Тоглолт үзүүлэх зэрэг зайлшгүй нүүр царайгаа гаргах нөхцөл байдал гэх мэт.

<Энэхүү орчуулгыг Данүри лавлах төв1577-1366 хийв.>